



**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ДОТООД
АУДИТЫН АЛБА**

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2025 ОНД
ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 ОН

**СҮХБААТАР ДҮҮРГИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
2025 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 15

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Дотоод аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиглэлээр тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийг бодит мэдээллээр ханган шалгагдсан байгууллагын төсвийн шууд захирагч, санхүү бүртгэлийн ажилтнуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хугацаанд нь хийж, зөвлөмжийн биелэлтийг тооцож ажиллалаа.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.3, Монгол улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 4.10 дугаар заалтын дагуу албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүүргийн Засаг даргатай байгуулж ажиллав.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагын үйл ажиллагаанд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, төсөв, санхүү төсвийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан мэдээлж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулж ажилласан.

Тайлант хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан төрийн өмчийн 6 сургууль, 14 цэцэрлэг, Сүхбаатар дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Засаг даргын дэргэдэх байгууллага 3, нийцлийн аудитад 24 байгууллага, өргөдөл, хүсэлтээр 15 дотоод аудит, нийт 59 санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийж, нийт **4,937,810.4** мянган төгрөгийн зөрчил илрүүлж ажилласан.

Хяналт шалгалтын тоон үзүүлэлт

д/д	Төрөл	Хийсэн тоо	Хамрагдсан байгууллага	Илрүүлсэн зөрчил	Илрүүлсэн зөрчлийг /%-иар/
1	Санхүүгийн хяналт шалгалт	1	1	1,724,423.9	35.0
2	Дотоод аудит	23	23	1,244,766.1	25.2
3	Нийцлийн аудит	2	20	1,265,634.1	25.6
4	Өргөдлийн дагуу хийгдсэн шалгалт	7	15	702,986.3	14.2
	НИЙТ		59	4,937,810.4	100.0

Аудитын тоон үзүүлэлт:

Төсвийн захирагч	Хамрагдсан байгууллага	Нийт зөрчил		Албан шаардлага		хэрэгжилт	
		Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
ТЕЗ	2	1	20,177.6				
ТТЗ	20	16	1,224,588.5	1	224,463.9	1	224,463.9
ОНӨААТҮГ	1						
	23	17	1,244,766.1	1	224,463.9	1	224,463.9

Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр:

		Нийт зөрчил	хэрэгжилт
--	--	-------------	-----------

Төсвийн захирагч	Хамрагдсан байгууллага	Тоо	дүн	тоо	дүн
ТТЗ	1	1	1,724,423.9	1	1,724,423.9
	1	1	1,724,423.9	1	1,724,423.9

Нийцлийн аудитаар:

Төсвийн захирагч	Хамрагдсан байгууллага	Нийт зөрчил		хэрэгжилт	
		Тоо	дүн	тоо	дүн
ТТЗ /4/	4	3	1,265,634.1	3	1,265,634.1
ТТЗ /16/	16	5	1,166,983.4	5	1,166,983.4
	20	8	2,432,617.5	8	2,432,617.5

Өргөдөл, хүсэлтээр хийгдсэн аудитаар:

Төсвийн захирагч	Хамрагдсан байгууллага	Нийт зөрчил		Албан шаардлага		хэрэгжилт	
		Тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
ТЕЗ	2	1	104,424.8	1	104,424.8	1	104,424.8
ТТЗ	11	4	532,384.8	2	502,054.8	2	502,054.8
бусад	2	1	66,176.7				
	15	5	702,986.5	3	606,479.6	3	606,986.5

Хоёр. Зохион байгуулж, оролцсон сургалт, сурталчилгаа

1. Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн 59 байгууллагын удирдах болон санхүүгийн 165 ажилтанд Монгол Улсын Шилэн дансны тухай хууль болон байгууллагын дотоод хяналтын хэрэгжилтийн талаар аудит хийгдэх тухай бүр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

2. Монгол Улсын Сангийн яам, Баянгол дүүргийн Дотоод аудитын албатай хамтран зохион байгуулсан Улсын салбарын дотоод аудитын ажилтнуудыг чадавхижуулах сургалт 2025 оны 05 сарын 30-ны өдөр болж сургалтад албаны дарга, 2 аудиторын хамт оролцлоо.

3. Сүхбаатар дүүргийн 60 жилийн ойг угтан Сүхбаатар дүүргийн ЗДТГазар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс, нэгж, байгууллагуудын дунд зохион байгуулагдсан "SBD QUIZ-60" мэдлэг сорих, танин мэдэхүйн тэмцээнд 2025 оны 06 сарын 04-ний өдөр ахлах аудитор Б.Ариунаа, аудитор Д.Цэцэгсүрэн, бичиг хэрэг М.Энхжаргал нар Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвтэй хамтран 6 хүний бүрэлдэхүүнтэй Сонор багийг бүрдүүлэн амжилттай оролцлоо.

4. Албаны дарга Сүхбаатар дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд 12 удаа оролцож, зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгаварын хэрэгжилтийг хангуулж ажиллалаа.

5. Монгол Улсын Сангийн яам Азийн Хөгжлийн банктай хамтран Улсын салбарын дотоод аудиторуудыг чадавхижуулах, олон улсын туршлага судлах сургалт 2025 оны 11 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд /Corporate Convention/-д зохион байгуулж тус албанаас 2 аудитор оролцлоо.

Гурав. Санхүү, төсвийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

Сангийн яамнаас гаргасан Улсын салбарын Дотоод аудитын аргачлалын дагуу байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын төлөвшил "Хангалттай"-53, "сайжруулах шаардлагатай"-5, "хангалтгүй"-1 дүгнэлт гарган, зөвлөмж өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Ахлах аудитор, дотоод аудиторууд 59 байгууллагад хийсэн санхүүгийн болон нийцлийн аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх ажлын явцад нийт 4,937,810.4 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн дүгнэлт өгч зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн тухай бүр ажлын баримтаар архивын нэгж үүсгэн ажиллаж байна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн хүсэлт, иргэдээс ирүүлсэн өргөдлийн дагуу төлөвлөгөөт бус аудитыг хийсэн. Үүнд:

1. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Мөрдөгчийн мэдэгдлийн хэрэгжилтийг хангуулахаар Сүхбаатар дүүргийн 35 дугаар сургууль, “Эрдмийн хөтөч” цогцолбор сургууль, Насан туршийн боловсролын төв, 130, 150, 166, 205, 217, 283 дугаар цэцэрлэгийн бохир усны төлбөрийн 2022-2024 оны гүйлгээнд хяналт шалгалт хийж 32,330.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 43-05/01 тоот албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч, албан шаардлагын хэрэгжилтийг эргэн хянаж зөрчлийг арилгуулж ажилласан.

Аудитын дүнг АТГ-ын Мөрдөн шалгах хэлтэст 2025 оны 06 сарын 03-нд 16 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

2. Нийслэлийн Дотоод аудитын абанаас ирүүлсэн 1/90 тоот албан бичгийн дагуу “Манай эмч” өрхийн эрүүл мэндийн төвийн 2022-2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж 73,008.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж илэрсэн зөрчлийг арилгуулахаар 43-05/03 тоот албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, албан шаардлагын хэрэгжилтийг эргэн хянаж зөрчлийг арилгуулж ажилласан.

3. Сүхбаатар дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн Дотоод хяналтыг хэрэгжүүлэх тухай 1/405 дугаар албан бичгийн дагуу 2025 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн, явцад аудит хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж бичиж дүнг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлээ.

4. Сүхбаатар дүүргийн Засаг даргаас 2025 оны 05 сарын 20-ны өдөр ирүүлсэн Хяналт шалгалт хийлгэх тухай 01/1306 дугаар албан бичгийн дагуу Сүхбаатар дүүргийн Ахмадын хороо НҮТББ-ын 2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж 102,424.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 43-05/02 тоот албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгавар өгч өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажилласан.

5 Сүхбаатар дүүргийн Засаг даргаас 2025 оны 08 сарын 07-ны өдөр ирүүлсэн Хяналт шалгалт хийлгэх тухай 01/2152 дугаар албан бичгийн дагуу “Манай эмч” өрхийн эрүүл мэндийн төвийн 2020-2024 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж 429,046.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 43-05/04 тоот албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч ажилласан.

6. Сүхбаатар дүүргийн Засаг даргаас 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн Хяналт, шалгалт хийлгэх тухай 01/2914 дугаар албан бичгийн дагуу “Могол-20” СӨХ-ны 2022-2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийж 66,176.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж илэрсэн зөрчлийн арилгуулахаар зөвлөмж өгч ажилласан.

7. Сүхбаатар дүүргийн Засаг даргаас 2025 оны 12 сарын 05-ны өдөр ирүүлсэн Хүсэлт уламжлах тухай 01/3219 дугаар албан бичгийн дагуу “Дархан Өргөө” СӨХ-ны 2024-2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн аудит хийхээр удирдамж боловсруулан батлуулж аудит хийгдэж байна

Мөн өмнөх онуудад хийгдсэн дотоод аудитаар өгсөн зөвлөмж, санхүүгийн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмжийн хэрэгжилт, Нийслэл дэх Төрийн аудитын газраас дүүргийн санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн дүгнэлт, байгууллага бүр дээр гарсан зөрчлийг харгалзан аудит хийгдсэн байгууллагуудын илэрч буй зөрчлийн жагсаалт гарган эрсдэлийг үнэлж, эрсдэлийн санг баяжуулан хяналт тавьж ажиллав.

Дөрөв. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Дүүргийн Засаг Даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.5 заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр:

1. Сүхбаатар дүүргийн төсвийн болон орон нутгийн өмчит 76 аж ахуйн нэгж, байгууллагын шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байдлыг сар бүр шалган дүнг Санхүү Төрийн сангийн хэлтэст илгээж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 99.0 % ханган ажилласан байна. Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн 76 байгууллагын нягтлан бодогчдод Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөгөө өгч ажилласан.

2. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төсвийн болон орон нутгийн өмчит 39 аж ахуйн нэгж байгууллагад аудит хийхдээ дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн байгууллагуудын төлөвлөгөө, хөтөлбөрт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах аар тусган Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

3. Сүхбаатар дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 51, 54, 69, 75 дугаар цэцэрлэгийн 2023-2024 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд Нийцлийн аудит хийж төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроосон, байршуулаагүй 1,185,470.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн нөхөж байршуулсан.

Тав. Удирдлага зохион байгуулалт

Тус алба нь дарга 1, ахлах аудитор 1, аудитор 1, архив, бичиг хэргийн ажилтан 1, нягтлан бодогч 1 нийт 5 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Сүхбаатар дүүргийн Засаг даргын 2025 оны 12 сарын 10-ны өдрийн А/662 дугаар захирамжаар тус албаны бүтэц, орон тоог шинэчлэн баталсан. Үүнд:

д/д	Албан тушаал	Орон тоо	ангилал	зэрэглэл
1	Албаны дарга	1	ТЗ	5
2	Ахлах аудитор	2	ТЗ	6
3	Дотоод аудитор	3	ТЗ	7
4	Нягтлан бодогч	1	ТҮМ	7
5	Бичиг хэрэг, архивын ажилтан	1	ТҮМ	5
6	Нярав	1	ТҮ	4

Одоогоор тус алба нь дарга 1, ахлах аудитор 1, аудитор 1, архив, бичиг хэргийн ажилтан 1, нягтлан бодогч 1 нийт 5 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Албаны дарга ахлах аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, дотоод аудитор 1 нийт 2 ажилтны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, бичиг хэрэг 1, нягтлан бодогч 1, үйлчлэгч 1, нийт 3 ажилтантай хөдөлмөрийн гэрээг байгуулан ажилласан.

2025 онд төлөвлөсөн ажлаа бүрэн гүйцэт биелүүлж ажилласан бөгөөд иргэдээс ирүүлсэн өргөдөл, хүсэлт, дээд шатны байгууллагаас ирүүлсэн хүсэлтээр нийт 59 байгууллагад аудит хийлээ.

Төрийн албаны үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа болон салбарын хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг судалж, мэдлэг боловсролоо байнга дээшлүүлж шинээр батлагдсан хууль дүрэм журмыг ажилдаа бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна.

Эрсдэлийн удирдлага, хараат бус аудит, дотоод аудитын чиглэлээр мэргэшиж, эрсдэлд суурилсан дотоод аудит, хяналт шалгалтыг хэрэгжүүлэн чанарын хяналтыг тогтмол хийж багаараа хамтран ажиллаж байна.

Архив, албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлт

Тайлангийн хугацаанд албанд 72 албан бичиг ирж, харилцагч байгууллагад 34 албан бичиг явуулж албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөн ажилласан.

Ирсэн албан бичгийн хариуг шууд шийдвэрлэх боломжтой нөхцөлд тэр даруйд нь шийдвэрлэн, хуулийн хугацаанд 100.0 хувь шийдвэрлэж бичиг хэргийн эргэлтэд байнгын хяналт тавьж ажиллалаа.

Албаны дарга А тушаал 14, Б тушаал 7-г гаргаж тухай бүрт нь холбогдох албан тушаалтанд танилцуулан хэрэгжилтийг бүрэн хангасан. Тушаал гаргахдаа эрх зүйн үндэслэлийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гарган ажиллаж байна.

2025 онд үйлдсэн баримт бичиг

д/д	Баримт бичгийн төрөл	тоо
1	Албан бичиг	34
2	Даргын А тушаал	14
3	Даргын Б тушаал	7
4	Хурлын тэмдэглэл	2
5	Санхүүгийн хяналтын тайлан	1
6	Аудитын тайлан, дүгнэлт	32
7	Улсын ахлах байцаагчийн албан шаардлага	4

2024 оны жилийн эцсийн байдлаар үүссэн баримтыг архивын ажлын үндсэн заавар ХХНЖ-н дагуу эмхлэн цэгцэлж, үдэж хавтаслан, нүүр бичилт хийж хадгалалтын хугацаагаар нь ангилан хөмрөг үүсгэв.

Тус албаны архивт одоогийн байдлаар 256 архивын нэгж хадгалагдаж байна.

70 жил хадгалах-40

Түр хадгалах- 132

Байнга хадгалах- 84

Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт

д/д	Үндсэн чиглэл, хөтөлбөр	Төлөвлөсөн арга хэмжээний заалтуудын хэрэгжилт	Хэрэг жил тийн хувь
1	Дүүргийн Засаг Даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.5 заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр:	1. Сүхбаатар дүүргийн төсвийн болон орон нутгийн өмчит 76 аж ахуйн нэгж, байгууллагын шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байдлыг сар бүр шалган дүнг Санхүү Төрийн сангийн хэлтэст илгээж ажилласан. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 99.0 % ханган ажилласан байна. Сүхбаатар дүүргийн төрийн өмчийн 76 байгууллагын нягтлан бодогчдод Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар зөвлөгөө өгч ажилласан. 2. 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу төсвийн болон орон нутгийн өмчит 39 аж ахуйн нэгж байгууллагад аудит хийхдээ дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийсэн байгууллагуудын төлөвлөгөө, хөтөлбөрт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахаар тусган Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. 3. Сүхбаатар дүүргийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 51, 54, 69, 75 дугаар цэцэрлэгийн 2023-2024 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд Нийцлийн аудит хийж төсөв, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хуульд заасан	100.0%

		хугацаанаас хоцроосон, байршуулаагүй 1,185,470.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн нөхөж байршуулсан.	
2	Монгол Улсын Засгийн газраас зарласан "Авлигатай тэмцэх жил"-ийн хүрээнд	1.Дотоод аудитын албаны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд 18 ажлыг хийхээр төлөвлөн биелэлтийг ханган ажилласан. 2.Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Авилгатай тэмцэх газарт зохих журмын дагуу хуулийн хугацаанд хүргүүлэв. 3.Хөрөнгө орлогын мэдүүлгийг 4 албан хаагч хуулийн хугацаанд мэдүүлж баталгааны хуудас гарган ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан. 4.Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх бүрд ашиг сонирхолын зөрчилгүй мэдүүлгийн хуудас 59 удаа гарган ажилласан.	100.0%
3	Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт	2025 онд 7 өргөдөл, хүсэлтээр аудит хийж 702,986.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн илэрсэн зөрчлийг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн албан шаардлага 3-ыг бичиж хэрэгжилтийг хангуулан ажилласан.	100.0%
4	Төрийн байгууллагын нээлттэй ил тод байдлыг хангах	Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор албаны https://sbd-audit.gov.mn/ вебсайт хийлгэн байнгын тогтмол ажиллагаанд оруулж албаны мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчлан ажиллаж байна.	100.0%
5	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган цахим мэдээллийн хуудсанд байршуулбал зохих 183 мэдээллийг заасан хугацаанд байршуулсан.	100.0%
6	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	Тус албаны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 20 ажил хийхээр төлөвлөж, төлөвлөсөн ажлаа 100.0% биелүүлж ажилласан.	100.0%

Зургаа. Төсөв санхүүгийн үйл ажиллагаа

Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албаны зорилго зорилт үйл ажиллагаатай уялдуулж төсвийн төсөл хийж, батлуулж ажиллав.

2025 онд 417,263.0 мянган төгрөгийн төсөв батлагднаас эхний хагас жилд 243,826.1 мянган төгрөгийг зарцуулж, 173,437.6 мянган төгрөгийг хэмнэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Төсвийн гүйцэтгэл /2025 он/

/мянган төгрөгөөр/

үзүүлэлт	2025 он			
	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	Зардалд эзлэх хувиар
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417,263.7	275,774.6	173,437.6	
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	417,263.7	275,774.6	173,437.6	100.0%
Бараа, үйлчилгээний зардал	350,748.3	275,774.6	83,725.0	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	265,543.1	214,467.3	51,075.8	77.8%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,192.8	33,371.8	8,572.2	12.2%
Хангамж, бараа материалын зардал	14,012.4	9,782.6	4,229.8	3.5%
Эд хогшил, урсгал засварын зардал	20,000.0	730.4	19,269.6	0.2%

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	6,000.0	4,366.5	1,633.5	1.6%
Бараа үйлчилгээний бусад зардал	12,000.0	2,500.0	9,500.0	0.9%
Урсгал шилжүүлэг	66,515.4	10,556.0	55,959.4	3.8%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	417,263.7	300,724.0	116,539.7	
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	417,263.7	300,724.0	116,539.7	
Орон нутгийн төсвөөс	417,263.7	300,724.0	116,539.7	

2025 оны төсвийн 77.8 хувь цалинд, 12.2 хувь нийгмийн даатгалын шимтгэлд, эд хогшил, урсгал засварын зардалд 0.2 хувь, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 1.6 хувь, бараа үйлчилгээний бусад зардалд 0.9 хувь, урсгал шилжүүлэгт 3.8 хувийг тус тус зарцуулсан.

Нийслэл дэх Төрийн аудитын газраас 2024 оны Дүүргийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар тус алба нь зөрчилгүй дүгнэлт авсан.

Батлагдсан төсвийг зардлын зүйл анги бүрээр зарцуулж сар бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээ, улирлын тайланг хуульд заасан хугацаанд гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн, шилэн дансны цахим мэдээллийн сан www.shilendans.gov.mn болон мэдээллийн самбарт 183 мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын эзэмшилд байгаа хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, хөрөнгийг коджуулж, хүн бүрт картлан хүлээлгэн өгч, бүртгэлээр тавих хяналт, дотоодын хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн санхүүжилт бүртгэл, хөдөлгөөний талаар хууль дүрэм журамд нийцүүлж ажилласан.

Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж, нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг Авилгатай тэмцэх газарт зохих журмын дагуу хуулийн хугацаанд хүргүүлэв.

Дүгнэлт

Сүхбаатар дүүргийн Засаг даргатай 2025 онд байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, 59 байгууллагад санхүүгийн аудит болон санхүүгийн хяналт шалгалт хийж 4,937,810.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан.

Тус албанд 2025 онд 417,263.0 мянган төгрөгийн төсөв батлагднаас 243,826.1 мянган төгрөгийг зарцуулж, 173,437.6 мянган төгрөгийг хэмнэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Сүхбаатар дүүргийн төсвийн болон орон нутгийн өмчит 76 аж ахуйн нэгж, байгууллагын шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байдалд сар бүр хяналт тавьж ажилласан.

Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор албаны <https://sbd-audit.gov.mn/> вебсайт хийлгэн байнгын тогтмол ажиллагаанд оруулж албаны мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчлан ажиллаж байна.

ХЯНАСАН:
АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.САЙНБУЯН

ТАЙЛАН БИЧСЭН:
АХЛАХ АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ

A handwritten signature in black ink, written in a cursive style.

Б.АРИУНАА